

БАТЛАВ
НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ
ГАЗРЫН ДАРГА *С. Аюулмаа* В ОЮУМАА

2025 оны 02 дугаар сарын 22

НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН НЭЭЛТТЭЙ МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДЛЫГ
ХЭРЭГЖҮҮЛЭХ 2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

2025 оны 02 дугаар сарын 20

Улаанбаатар хот

№	Нээлттэй мэдээлэл	Шалгуур үзүүлэлт	Хүлээлгэн өгөх баримтын жагсаалт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хугацаа	Хариуцах нэгж
		/МХБ, ХНБ, МБББ, ЭСТБ/					
Нэг.Чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал							
1.1	Эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт, тэргүүлэх чиглэл, тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүнг тайлагнах, байгууллагын цахим хуудаст ил тод байршуулах	Шалгуур үзүүлэлтийн оноо, Гүйцэтгэлийн хувь	-Гүйцэтгэлийн төлөвлөгөө, тайлан -Үйл ажиллагааны стратеги төлөвлөгөө, тайлан -Бүтэц, зохион байгуулалттай холбоотой захирамж, тушаал	-	100%	I-IV улирал	ЗУХ
1.2	Байгууллагын хаяг, байршил, харилцах утасны дугаар, шуудангийн хаяг, олон нийттэй харилцах, мэдээлэл хүргэх нийгмийн сүлжээний хаяг болон байгууллагын албан тушаалтны эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, албаны харилцах утасны дугаар, албаны цахим шуудангийн хаягийг байгууллагын цахим хуудаст ил тод байршуулах	Шалгуур үзүүлэлтийн оноо, Гүйцэтгэлийн хувь	-Байгууллагын хаяг, байршил, харилцах утасны дугаар, шуудангийн хаяг, олон нийттэй харилцах, мэдээлэл хүргэх нийгмийн сүлжээний хаягууд -Албан тушаалтны эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, албаны харилцах утасны дугаар, өрөөний дугаар -Албан хаагчдын албаны цахим шуудангийн хаяг umch@ub.gov.mn	-	100%	I-IV улирал	ЗУХ

1.3	Үйл ажиллагааны тайлан, мэдээлэл хариуцагчийн үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээг байгууллагын цахим хуудаст ил тод байршуулах	Шалгуур үзүүлэлтийн оноо, Гүйцэтгэлийн хувь	-Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, биелэлтэд хийсэн үнэлгээ	-	100%	I-IV улирал	Нийт хэлтэс
1.4	Дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтын тайлан, акт, дүгнэлт, албан шаардлага, зөвлөмж, албан шаардлага зөвлөмжөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээг байгууллагын цахим хуудаст ил тод байршуулах	Шалгуур үзүүлэлтийн оноо, Гүйцэтгэлийн хувь	- Дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтын тайлан -Акт, дүгнэлт, албан шаардлага, зөвлөмж, -Албан шаардлага зөвлөмжөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ	-	100%	I-IV улирал	ЗУХ
1.5	Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг тайлагнах, хэрэгжилтийг байгууллагын цахим хуудаст ил тод байршуулах	Шалгуур үзүүлэлтийн оноо, Гүйцэтгэлийн хувь	-Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийн тайлан	-	100%	I-IV улирал	Нийт хэлтэс
1.6	Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтийн тайлагнах, хэрэгжилтийг байгууллагын цахим хуудаст ил тод байршуулах	Шалгуур үзүүлэлтийн оноо, Гүйцэтгэлийн хувь	-Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтийн тайлан	-	100%	I-IV улирал	Нийт хэлтэс
1.7	Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, бусад эрх зүйн актыг байгууллагын цахим хуудас болон Ublegal хуудаст ил тод байршуулах	Шалгуур үзүүлэлтийн оноо, Гүйцэтгэлийн хувь	-Хууль, эрх зүйн акт -НӨХГ-ын дүрэм, журам -НЗД-ын захирамж -НИТХ-ын тогтоол -НӨХГ-ын даргын тушаал	-	100%	I-IV улирал	ЗУХ
1.8	Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийг улирал бүр тайлагнаж, хэрэгжилтийг байгууллагын цахим хуудаст ил тод байршуулах	Шалгуур үзүүлэлтийн оноо, Гүйцэтгэлийн хувь	-Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайлан	-	100%	I-IV улирал	ЗУХ
1.9	Хуульд өөрөөр заагаагүй бол хариуцсан салбарын үйл ажиллагааны статистик мэдээллийг байгууллагын цахим хуудаст ил тод байршуулах	Шалгуур үзүүлэлтийн оноо, Гүйцэтгэлийн хувь	-Үйл ажиллагааны статистик мэдээлэл	-	100%	I-IV улирал	Нийт хэлтэс

1.10	Мэдээлэл хариуцагчаас зохион байгуулах олон нийтийн арга хэмжээний хөтөлбөр, биелэлтийг тайлагнах, байгууллагын цахим хуудаст ил тод байршуулах	Шалгуур үзүүлэлтийн оноо, Гүйцэтгэлийн хувь	-НӨХГ-аас зохион байгуулсан олон нийтийн арга хэмжээний тайлан	-	100%	I-IV улирал	ЗУХ
Хоёр.Хүний нөөцийн талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал							
2.1	Ажлын байрны сул орон тооны талаарх мэдээллийг байнга шинэчлэн, байгууллагын цахим хуудаст ил тод байршуулах	Шалгуур үзүүлэлтийн оноо, Гүйцэтгэлийн хувь	-Ажлын байрны сул орон тооны зар, мэдээ	-	100%	I-IV улирал	ЗУХ
2.2	Албан хаагч, ажилтныг сонгон шалгаруулах журмыг байгууллагын цахим хуудаст ил тод байршуулах	Шалгуур үзүүлэлтийн оноо, Гүйцэтгэлийн хувь	-Албан хаагч, ажилтныг сонгон шалгаруулах журам	-	100%	I-IV улирал	ЗУХ
2.3	Албан хаагч, ажилтны ёс зүйн дүрмийг байгууллагын цахим хуудаст ил тод байршуулах	Шалгуур үзүүлэлтийн оноо, Гүйцэтгэлийн хувь	-Албан хаагч, ажилтны ёс зүйн дүрэм	-	100%	I-IV улирал	ЗУХ
2.4	Хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж үнэлэх журмыг байгууллагын цахим хуудаст ил тод байршуулах	Шалгуур үзүүлэлтийн оноо, Гүйцэтгэлийн хувь	-Хүний нөөцийн стратеги, хөгжлийн хөтөлбөр -Сургалт хөгжлийн журам -Шинэ албан хаагчийг чиглүүлэх, дадлагажуулах журам -Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр -Хэрэгжилтийг хянаж үнэлэх журам	-	100%	I-IV улирал	ЗУХ
2.5	Хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний хөтөлбөр, хэрэгжилтийг байгууллагын цахим хуудаст ил тод байршуулах	Шалгуур үзүүлэлтийн оноо, Гүйцэтгэлийн хувь	-НӨХГ-ын Сургалтын төлөвлөгөө, хэрэгжилт -Жендерийн эрх тэгш байдлыг хангах үйл ажиллагааны төлөвлөгөө, хэрэгжилт -Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн	-	100%	I-IV улирал	ЗУХ

			баталгааг хангах хөтөлбөр, биелэлт -Хүний нөөцийн удирдлагын ил тод байдалд холбогдох бусад төлөвлөгөө, түүний хэрэгжилт				
2.6	Албан хаагчийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх журам, албан хаагчдын хагас жил, жилийн эцсийн гүйцэтгэлийн тайлан, үнэлгээг байгууллагын цахим хуудаст ил тод байршуулах	Шалгуур үзүүлэлтийн оноо, Гүйцэтгэлийн хувь	-Албан хаагчийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх журам	-	100%	I-IV улирал	ЗУХ
Гурав. Төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал							
3.1	Өмнөх оны төсвийн гүйцэтгэл, тухайн жилийн төсөв, дараа оны төсвийн төслийг shilendans болон байгууллагын цахим хуудаст ил тод байршуулах	Шалгуур үзүүлэлтийн оноо, Гүйцэтгэлийн хувь	-Өмнөх оны төсвийн гүйцэтгэл, тухайн жилийн төсөв, дараа оны төсвийн төсөл	-	100%	I-IV улирал	ЗУХ
3.2	Төсвийн гүйцэтгэлийн биелэлт болон хагас, бүтэн жилийн санхүүгийн тайланг shilendans болон байгууллагын цахим хуудаст ил тод байршуулах	Шалгуур үзүүлэлтийн оноо, Гүйцэтгэлийн хувь	-Төсвийн гүйцэтгэлийн биелэлт болон хагас, бүтэн жилийн санхүүгийн тайлан	-	100%	I-IV улирал	ЗУХ
3.3	Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг shilendans болон байгууллагын цахим хуудаст ил тод байршуулах	Шалгуур үзүүлэлтийн оноо, Гүйцэтгэлийн хувь	-Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт	-	100%	I-IV улирал	ЗУХ
3.4	Хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг shilendans болон байгууллагын цахим хуудаст ил тод байршуулах	Шалгуур үзүүлэлтийн оноо, Гүйцэтгэлийн хувь	-Төсөвт төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ	-	100%	I-IV улирал	ЗУХ
3.5	Төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбарыг shilendans болон байгууллагын цахим хуудаст ил тод байршуулах	Шалгуур үзүүлэлтийн оноо, Гүйцэтгэлийн хувь	-Төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбар	-	100%	I-IV улирал	ЗУХ

3.6	Таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаягийг shilendans болон байгууллагын цахим хуудаст ил тод байршуулах	Шалгуур үзүүлэлтийн оноо, Гүйцэтгэлийн хувь	-Таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг	-	100%	I-IV улирал	ЗУХ
3.7	Цалингийн зардлаас бусад таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэрийн хамт shilendans болон байгууллагын цахим хуудаст ил тод байршуулах	Шалгуур үзүүлэлтийн оноо, Гүйцэтгэлийн хувь	-Цалингийн зардлаас бусад таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэрийн хамт	-	100%	I-IV улирал	ЗУХ
3.8	Шилэн дансны хөтлөлт, хэрэгжилт, аудитын тайлан, зөвлөмжийн дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний мэдээллийг shilendans болон байгууллагын цахим хуудаст ил тод байршуулах	Шалгуур үзүүлэлтийн оноо, Гүйцэтгэлийн хувь	-Шилэн дансны хөтлөлт, хэрэгжилт, аудитын тайлан, зөвлөмжийн дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний мэдээлэл	-	100%	I-IV улирал	ЗУХ
3.9	Тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгааныг shilendans болон байгууллагын цахим хуудаст ил тод байршуулах	Шалгуур үзүүлэлтийн оноо, Гүйцэтгэлийн хувь	-Тендерийн журам, баримт бичиг, тендерийн урилга, оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл	-	100%	I-IV улирал	ЗУХ ӨУЗХ ХЗХ
3.10	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, худалдан авах ажиллагаанд хийсэн үнэлгээ болон аудитын тайлан, дүгнэлтийг shilendans болон байгууллагын цахим хуудаст ил тод байршуулах	Шалгуур үзүүлэлтийн оноо, Гүйцэтгэлийн хувь	-Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө -Худалдан авах ажиллагаанд хийсэн үнэлгээ болон аудитын тайлан, дүгнэлт	-	100%	I-IV улирал	ЗУХ

3.11	Төсвийн гүйцэтгэл болон аудитын санхүүгийн нэгтгэсэн тайланг shilendans болон байгууллагын цахим хуудаст ил тод байршуулах	Шалгуур үзүүлэлтийн оноо, Гүйцэтгэлийн хувь	-Төсвийн гүйцэтгэл -Аудитын хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан	-	100%	I-IV улирал	ЗУХ
Дөрөв. Үзүүлж байгаа үйлчилгээний талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал							
4.1	Үйлчилгээний төрөл, шийдвэрлэх журам, хугацаа, бүрдүүлэх баримт бичиг, түүний загвар, төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ, төлбөр төлөх дансны мэдээллийг байгууллагын цахим хуудаст ил тод байршуулах	Шалгуур үзүүлэлтийн оноо, Гүйцэтгэлийн хувь	-НӨХГ-аас иргэн, хуулийн этгээдэд үзүүлэх үйлчилгээний төрөл, шийдвэрлэх журам, хугацаа, бүрдүүлэх баримт бичиг, түүний загвар, төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ, төлбөр төлөх дансны мэдээлэл	-	100%	I-IV улирал	ЗУХ
Тав.Бусад мэдээллийн ил тод, нээлттэй байдал							
5.1	Олон нийтээр хэлэлцүүлж, санал авч байгаа хууль тогтоомж болон захиргааны хэм хэмжээний актын төсөл, тэдгээрийн танилцуулга, холбогдох судалгаа, бусад байгууллага, иргэнээс өгсөн саналыг байгууллагын цахим хуудаст ил тод байршуулах	Шалгуур үзүүлэлтийн оноо, Гүйцэтгэлийн хувь	-Олон нийтээр хэлэлцүүлж, санал авч байгаа хууль тогтоомж, актын төсөлд санал өгсөн байдал, холбогдох судалгаа	-	100%	I-IV улирал	ХЗХ
5.2	Мэдээлэл хариуцагчийн эзэмшиж байгаа газрын мэдээллийг байгууллагын цахим хуудаст ил тод байршуулах	Шалгуур үзүүлэлтийн оноо, Гүйцэтгэлийн хувь	-Эзэмшиж байгаа газрын мэдээлэл	-	100%	I-IV улирал	ЗУХ
5.3	Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хувийн эрх зүйн хуулийн этгээдийн нэр, хаяг, дүрэм, үйл ажиллагааны чиглэл, эрх бүхий этгээдийн оруулсан хөрөнгийн хувь хэмжээ, ашиг, алдагдлын тайлан, нэгдсэн төсөвт төлсөн татварын хэмжээ, ногдол ашгийн мэдээллийг байгууллагын цахим хуудаст ил тод байршуулах	Шалгуур үзүүлэлтийн оноо, Гүйцэтгэлийн хувь	-Төрийн болон ОНӨААТҮГ-ын нэр, хаяг, дүрэм, үйл ажиллагааны чиглэл, эрх бүхий этгээдийн оруулсан хөрөнгийн хувь хэмжээ, ашиг, алдагдлын тайлан, нэгдсэн төсөвт төлсөн татварын хэмжээ, ногдол ашгийн мэдээлэл	-	100%	I-IV улирал	ЗУХ ӨУЗХ

5.4	Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хувийн эрх зүйн хуулийн этгээдийн удирдах зөвлөл, хяналтын зөвлөлийн бүтэц, бүрэлдэхүүн, тэдгээрийн гишүүн болон гүйцэтгэх удирдлагын эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, авч байгаа цалин хөлс, урамшууллын дүн, албаны цахим шуудангийн хаягийн талаарх мэдээллийг байгууллагын цахим хуудаст ил тод байршуулах	Шалгуур үзүүлэлтийн оноо, Гүйцэтгэлийн хувь	-Төрийн болон ОНӨААТҮГ-ын удирдах зөвлөл, хяналтын зөвлөлийн бүтэц, бүрэлдэхүүн, тэдгээрийн гишүүн болон гүйцэтгэх удирдлагын эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, авч байгаа цалин хөлс, урамшууллын дүн, албаны цахим шуудангийн хаяг	-	100%	I-IV улирал	ЗУХ ӨУЗХ
5.5	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийг хүн, хуулийн этгээдэд ашиглуулах, шилжүүлэх, хувьчлах, төсвийн хөрөнгийн ашиглалт болон түүнийг ашиглалтаас гаргах, ашиглалтаас гаргаснаас орсон орлогын талаарх мэдээллийг байгууллагын цахим хуудаст ил тод байршуулах	Шалгуур үзүүлэлтийн оноо, Гүйцэтгэлийн хувь	-Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийг хүн, хуулийн этгээдэд ашиглуулах, шилжүүлэх, хувьчлах, төсвийн хөрөнгийн ашиглалт болон түүнийг ашиглалтаас гаргах, ашиглалтаас гаргаснаас орсон орлогын талаарх мэдээлэл	-	100%	I-IV улирал	ЗУХ ӨУЗХ
5.6	Авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчилсан байдал, авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төлөвлөгөө, тайланг байгууллагын цахим хуудаст ил тод байршуулах	Шалгуур үзүүлэлтийн оноо, Гүйцэтгэлийн хувь	-Авлигын эсрэг хууль тогтоомж, мэдээ мэдээлэл, суртал ухуулга -Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан	-	100%	I-IV улирал	ЗУХ
5.7	Албан тушаалтны нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8.1-д заасан ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэл болон энэ хуулийн 8.6-д заасан тайлбарыг байгууллагын цахим хуудаст ил тод байршуулах	Шалгуур үзүүлэлтийн оноо, Гүйцэтгэлийн хувь	-Албан тушаалтны ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэл болон тайлбар	-	100%	I-IV улирал	ЗУХ

5.8	Төрийн албаны зөвлөлийн болон салбар зөвлөлийн дүгнэлт, нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг (ХАСУМ)-ийг хянасан дүгнэлтийг байгууллагын цахим хуудаст ил тод байршуулах	Шалгуур үзүүлэлтийн оноо, Гүйцэтгэлийн хувь	-Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг (ХАСУМ)-ийг хянасан дүгнэлт	-	100%	I-IV улирал	ЗУХ
5.9	Хууль болон олон улсын гэрээгээр нээлттэй байхаар заасан бусад мэдээллийг байгууллагын цахим хуудаст ил тод байршуулах	Шалгуур үзүүлэлтийн оноо, Гүйцэтгэлийн хувь	-Хууль болон олон улсын гэрээгээр нээлттэй байхаар заасан бусад мэдээлэл	-	100%	I-IV улирал	Нийт хэлтэс

ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЯНАСАН:
ЗАХИРГАА УДИРДЛАГЫН
ХЭЛТСИЙН ДАРГА



/Т.ОЮУНТУУЛ/

ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЯНАН, ШАЛГАСАН:
ӨМЧИЙН ХЯНАЛТ, ШАЛГАЛТЫН ХЭЛТСИЙН
МЭРГЭЖИЛТЭН



/Б.АДЪЯА/

ТӨЛӨВЛӨГӨӨГ БОЛОВСРУУЛСАН:
ЗАХИРГАА УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
ГАДААД, ДОТООД ХАМТЫН АЖИЛЛАГАА
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН



/Ж.ҮҮРИЙНТУЯА/

НЭЭЛТТЭЙ МЭДЭЭЛЛИЙГ ИЛ ТОД БАЙЛГАХ БОЛОН ИЛ ТОД БАЙДЛЫН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ ТОГТООХ, ҮНЭЛГЭЭ ХИЙХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Энэ журам нь Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 6.1-д заасан нийтийн мэдээлэл хариуцагч (цаашид “мэдээлэл хариуцагч” гэх) мөн хуулийн 8.2-8.6-д заасан нээлттэй мэдээллийн ил тод байдлын шалгуур үзүүлэлтийг тогтоох, 8.17-д заасан хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэдэх “Нээлттэй мэдээллийн ил тод байдлын хэрэгжилтийг зохион байгуулах, үнэлгээ хийх, зөвлөмж гаргах чиг үүрэг бүхий орон тооны бүс зөвлөл” (цаашид “Зөвлөл” гэх) нээлттэй мэдээллийн ил тод байдлын үнэлгээ хийх, зөвлөмж гаргах, арга зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулна.

1.2.Мэдээлэл хариуцагч нээлттэй мэдээллийн ил тод байдлыг хангахад Засгийн газрын 2022 оны 201 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Нээлттэй мэдээллийг цахим хэлбэрээр байршуулж нийтлэх, шинэчлэх, хяналт тавих нийтлэг журам”-ыг мөрдөнө.

1.3.Мэдээллийн ил тод байдлын үнэлгээ хийхэд дараахь зарчмыг баримтална:

1.3.1.шударга, хараат бус байх;

1.3.2.үнэлгээ нь нээлттэй, олон нийтийн оролцоог хангасан байх;

1.3.3.үнэлгээний тайлан, дүгнэлт нь ил тод байх;

1.3.4.үнэлгээ нь шалгуур үзүүлэлт, мэдээ тайланд үндэслэсэн байх;

1.3.5.зөвлөмж нь ил тод байдлыг сайжруулахад чиглэсэн байх;

1.3.6.ил тод байдлын тайлан нь үнэн зөв, нотлогдохуйц байх;

1.3.7.үнэлгээний тайланд тусгагдсан мэдээллийн үнэн зөв байдлыг мэдээлэл хариуцагч хариуцдаг байх.

Хоёр.Нээлттэй мэдээллийн ил тод байдлыг үнэлэх шалгуур үзүүлэлт

2.1.Нээлттэй мэдээллийн ил тод байдлыг дараахь шалгуур үзүүлэлтээр үнэлнэ:

2.1.1.мэдээллийн хүртээмжтэй байдал - Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль (цаашид “хууль” гэх)-ийн 8.8-д заасны дагуу олон нийтэд ил тод мэдээлсэн эсэх;

2.1.2.хугацаандаа нийтлэгдсэн байдал - нээлттэй мэдээллийг хуулийн 8.9, 8.11-д заасан хугацаанд олон нийтэд хүргэсэн эсэх;

2.1.3.мэдээллийн бүрэн бүтэн байдал - нээлттэй мэдээллийг хуулийн 8.2-8.6-д заасан зохицуулалтын хүрээнд бүрэн гүйцэд тусгасан эсэх;

2.1.4.эх сурвалжийн тодорхой байдал-хуулийн нээлттэй мэдээллийг дэлгэрүүлж авах, тодруулах эх сурвалж, холбоо барих мэдээллийг цахим хуудсанд байршуулсан эсэх.

Гурав.Нээлттэй мэдээллийн ил тод байдлын үнэлгээ хийх аргачлал

3.1.“Мэдээллийн хүртээмжтэй байдал”-ыг (МХБ) дараахь аргачлалаар үнэлнэ:

3.1.1.нээлттэй мэдээллийг цахим хуудас, мэдээллийн самбар, бусад мэдээллийн хэрэгсэл ашиглан нийтэлсэн бол ХАНГАЛТТАЙ буюу 30 оноо;

3.1.2.нээлттэй мэдээллийг ДУТУУ буюу зөвхөн цахим хуудаст нийтэлсэн бол 15 оноо, мэдээллийн самбарт нийтэлсэн бол 10 оноо, бусад мэдээллийн хэрэгсэл ашиглан нийтэлсэн бол 5 оноо;

3.1.3.нээлттэй мэдээллийг нийтлээгүй бол ХАНГАЛТГҮЙ буюу 0 оноо.

3.2.“Хугацаандаа нийтлэгдсэн байдал”-ыг (ХНБ) дараахь аргачлалаар үнэлнэ:

3.2.1.нээлттэй мэдээллийг хуулиар тогтоосон хугацаанд нийтэлсэн, шинэчилсэн бол ХАНГАЛТТАЙ буюу 30 оноо;

3.2.2.нээлттэй мэдээллийг хуулиар тогтоосон хугацаанаас хойш нийтэлсэн, шинэчилсэн бол ДУТУУ буюу 10 оноо;

3.2.3.нээлттэй мэдээллийг нийтлээгүй, шинэчлээгүй бол ХАНГАЛТГҮЙ буюу 0 оноо.

3.3.“Мэдээллийн бүрэн бүтэн байдал”-ыг (МБББ) дараахь аргачлалаар үнэлнэ:

3.3.1.хуулиар 8.6-д заасан мэдээллийг ил тод байлгах үүрэг хүлээгээгүй мэдээлэл хариуцагчийн хувьд хуулийн 8.2, 8.3, 8.4, 8.5-д заасан нээлттэй мэдээллийг бүрэн гүйцэд нийтэлсэн бол 15 оноо, дуутуу нийтэлсэн бол 10 оноо, хуулийн 8.6-д заасан нээлттэй мэдээллийг бүрэн гүйцэд нийтэлсэн бол 15 оноо, дуутуу нийтэлсэн бол 5 оноо;

3.3.2.хуулийн 8.6-д заасан мэдээллийг ил тод байлгах үүрэг хүлээсэн мэдээлэл хариуцагчийн хувьд хуулийн 8.2, 8.3, 8.4, 8.5-д заасан нээлттэй мэдээллийг бүрэн гүйцэд нийтэлсэн бол 15 оноо, дуутуу нийтэлсэн бол 10 оноо, хуулийн 8.6-д заасан нээлттэй мэдээллийг бүрэн гүйцэд нийтэлсэн бол 15 оноо, дуутуу нийтэлсэн бол 5 оноо;

3.3.3.хуулийн 8.2, 8.3, 8.4, 8.5, 8.6-д заасан нээлттэй мэдээллийг нийтлээгүй бол 0 оноо.

3.4.“Эх сурвалжийн тодорхой байдал”-ыг (ЭСТБ) дараахь аргачлалаар үнэлнэ:

3.4.1.нээлттэй мэдээллийг дэлгэрүүлж авах, тодруулах эрх бүхий ажилтны харьяалах нэгжийн нэр, албан тушаал, нэр болон холбоо барих мэдээллийг нийтэлсэн бол ХАНГАЛТТАЙ буюу 30 оноо;

3.4.2.энэ журмын 3.4.1-д заасан мэдээллийн аль нэгийг нийтлээгүй бол ДУТУУ буюу 10 оноо;

3.4.3.энэ журмын 3.4.1-д заасан мэдээллийг нийтлээгүй бол ХАНГАЛТТҮЙ буюу 0 оноо.

3.5.Нээлттэй мэдээллийн ил тод байдлын үнэлгээний хувийг шалгуур үзүүлэлтийн оноонд үндэслэн дараахь аргачлалаар тооцож гаргана:

$$\text{Хэрэгжилтийн хувь} = \left(\frac{\text{МХБ} + \text{ХНБ} + \text{МБББ} + \text{ЭСТБ}}{120} \right) * 100$$

3.6. Үнэлгээний ерөнхий болон хэсгийн дундаж оноо, хувийг үзүүлэлтүүдийн оноо, хувийн арифметик дунджаар тооцно.

Дөрөв.Нээлттэй мэдээллийн ил тод байдалд
үнэлгээ хийх удирдлага, зохион байгуулалт

4.1.Мэдээлэл хариуцагч өөрийн хариуцсан асуудлын хүрээнд хамаарах нээлттэй мэдээллийн ил тод байдлыг энэ журмын 3 дугаар зүйлд заасан аргачлалаар үнэлж, “Нээлттэй мэдээллийн ил тод байдлын үнэлгээний хүснэгт”-ийн дагуу гаргах бөгөөд үнэлгээний тайланг салбарын хэмжээнд сайд, нутаг дэвсгэрийн хэмжээнд аймаг, нийслэлийн Засаг дарга нэгтгэж, бусад мэдээлэл хариуцагч жил бүрийн 2 дугаар сарын 1-ний өдрийн дотор Зөвлөлийн ажлын албанд тоон гарын үсгээр баталгаажуулан цахим хэлбэрээр хүргүүлнэ.

4.2.Зөвлөл ажлын алба нээлттэй мэдээллийн ил тод байдлын үнэлгээний тайланг хүлээн авч, үнэлгээг энэ журмын 3 дугаар зүйлд заасан аргачлалын дагуу хийгдсэн эсэхийг хянах бөгөөд үнэлгээнд өөрчлөлт оруулж болно.

4.3.Зөвлөлийн ажлын алба үнэлгээний цахим мэдээллийн сан үүсгэж, үнэлгээний тайлан, үнэлгээнд оруулсан өөрчлөлтийн талаарх мэдээллийг байршуулна.

4.4.Зөвлөлийн ажлын алба үнэлгээний нэгдсэн тайланг Зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлж, мэдээллийн ил тод байдлыг бүрэн хангаагүй мэдээлэл хариуцагчид зөвлөмж хүргүүлнэ.